

2020 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН МЭНДЧИЛГЭЭ



Г.Хатанболд

Төлөөлөн удирдах
зөвлөлийн дарга

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэндээ Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнөөс энэхүү мэндчилгээ хүрэх өдрийн мэнд хүргэе.

Монгол улсын Компанийн тухай хуульд заасанчлан эрхэм хувьцаа эзэмшигч та бүгдээр өмнөх оныхоо ажлаа дүгнүүлж, үр дүнгээ тайлагнах цаг бидний өмнө дахин ирлээ.

2020 онд дэлхий нийтийг хамарсан цар тахал гарч, улс орны хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдалд тусгай зохицуулалтаар ажилласан онцгой жил болж өнгөрлөө.

2020 он манай компанийн хувьд борлуулалтын орлого, харилцагчийн тоо, ашигт ажиллагаа зэрэг олон чухал үзүүлэлтээ багагүй хувиар нэмэгдүүлж чадсан амжилт дүүрэн жил байлаа.

Өнгөрсөн жилд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх удирдлагын баг болон ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, технологийн шинэчлэлт, түүний үйл ажиллагааны найдвартай байдлыг бэхжүүлэх, шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхтэй холбоотой чухал шийдвэрүүдийг гарган ажиллалаа.

ТУЗ-ийн хувьд өнгөрсөн онд компанийн хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг дээдлэн, хөрөнгө оруулалтын өгөөжийг өндөр байлгахад анхаарч, компанийн засаглал ил тод байдлыг нэмэгдүүлэхийг зорин ажилласан бөгөөд 2021 онд энэхүү чиг, зорилтоо баримтлан ажиллах болно.

Хүндэт хувьцаа эзэмшигч, найдвартай түнш, үнэнч хэрэглэгч та бүхний дэмжлэгтэйгээр Айтүүлс компани хөгжлийн шинэ шатанд гарч байгаагаа энэ дашрамд илэрхийлье.

Та бүхэнд өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

**Эрдэнэт хүний амь нас,
эрүүл мэндийг авч буй
энэхүү цар тахалтай дэлхий
нийтээрээ тэмцэж байна.
Ковид-19 цар тахлын үеийн
халдвар хамгааллын дэглэм
нь хүн төрөлхтний хувьд
мэдээллийн технологийг
салбар бүрт нэвтрүүлэх,
цахим шилжилтийг хийх
шаардлагыг эрчимжүүллээ.**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Б.Тамир

Гүйцэтгэх захирал

2020 онд Ковид-19 цар тахлын тархалт эрчимжиж Монгол улс төдийгүй, дэлхий нийтээрээ цар тахалтай тэмцсэн онцлог жил болж өнгөрлөө. Энэхүү цар тахлаас үүдсэн хорио цээрийн нөхцөлд Монгол улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүд буурч, голлох салбаруудын орлого хумигдан, бизнесийн салбарт маш том сорилт, эрсдэлийг авчирсан жил байлаа. Эдийн засгийн уналт үүссэн цаг үед “Айтүүлс” ХК-ийн хамт олон байгууллагынхаа өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн хэмжээнд тасралтгүй явуулж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, шинэ хэрэглэгчийн тоог нэмэгдүүлж, бизнес төлөвлөгөөг тасалдалд оруулахгүй байхад ихээхэн хүчин чармайлт гарган багаараа амжилттай ажиллаа.

Цар тахлын нөхцөл байдлаас улбаалан салбар бүрт цахим шилжилт өргөн цар хүрээтэйгээр эрчимжиж, цахим засаглал, цахим бизнес хүчээ авч, олон нийт ч цахим шилжилтийн чухлыг ойлгосон энэ үед бид энэхүү цахим шилжилтийн түүчээлэгч болж, Монгол улсын эдийн засаг, мэдээллийн технологийн салбарт өөрсдийн хувь нэмрээ оруулж, чанартай, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээр баялаг бүтээхийн зэрэгцээ бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагаандаа тогтмол сайжруулалт, өргөтгөл хийж, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалан, үүрэг хариуцлагаа ухамсарласан ажилласан жил байв.

Түүнчлэн дэлхий нийтээр үүлэн технологи руу шилжиж байгаа энэ үед 2018 оноос эхлэн “Фибо Клауд” ХХК-тай хамтран хөгжүүлсэн “Үндэсний үүлэн технологийн платформ”-ынхоо хүчин чадал, дэд бүтцийг тасралтгүй өргөтгөн, хөгжүүлэлт, сайжруулалтыг хийлээ. Өнөөдрийн байдлаар “Үндэсний үүлэн технологийн платформ”-ын нийт хэрэглэгчдийн 70 гаруй хувь нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг ААНБ-ууд байна.

Хүн төрөлхтний ирээдүй болсон мэдээллийн технологийн салбарт үнэлж баршгүй хувь нэмэр оруулан яваа эрхэм хөрөнгө оруулагчид, харилцагчид, түнш байгууллагууд болон бүтээлч хамт олондоо энэ өдрийн мэндийг хүргэе!

2020 онд цар тахлын нөлөөгөөр бүх шатны боловсролын байгууллага, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд, төр, хувийн хэвшил зэрэг бүхий л салбарт зайнаас ажиллах, дижитал шилжилтийг хурдасгах зайлшгүй шаардлага тулгарсан бөгөөд бидний хувьд 2020 оны томоохон ажлуудын нэг нь БШУЯ-тай хамтран “Сургалтын удирдлагын цогц систем”-ийг хөгжүүлэн, нутагшуулж хот, хөдөөгийн нийт нэг зуун мянган сурагчдыг тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролоор хангах, дөрвөн мянга орчим багшид ажлаа хийх боломжийг олгосон төслийг амжилттай хэрэгжүүлсэн явдал байв. Уг ажлын хүрээнд 2021 онд өмчийн бүх хэлбэрийн хувийн хэвшлийн ЕБС-дад уг системийг илүү өргөн хүрээтэйгээр нэвтрүүлэхээр өөрсдийн дата төв болон “Үндэсний үүлэн технологийн платформ”-ынхоо хүчин чадал, дэд бүтцээ өргөтгөн ажиллаж байна. Цахим шилжилт хурдсахын хэрээр дата төвийн хэрэгцээ шаардлага өдрөөс өдөрт өсөн нэмэгдсээр байна.

Компанийн санхүүгийн үзүүлэлтүүдийн хувьд өмнөх жилийн гүйцэтгэл болон төлөвлөгөөгөө давуулан биелүүлж, амжилт ололт дүүрэн ажилласныг дурдахад таатай байна. 2020 онд борлуулалтын орлого 5%-иар, цэвэр ашиг 28%-иар тус тус өссөн ба борлуулсан бүтээгдэхүүний өртөг 4%-иар буурсан үзүүлэлттэй байна. Олон улсын “PCI DSS” сертификаттай “Санхүүгийн дата төв”-ийг 2020 онд бүрэн ашиглалтад оруулсан нь борлуулалтын орлого болон цэвэр ашигт шууд нөлөө үзүүлсэн байгаагаас харвал хувьцаа эзэмшигчид та бүхний шийдвэр оновчтой байсан гэдгийн нотолгоо гэж үзэж байна. “Айтүүлс” ХК-ийн дата төвүүд нь тус онд олон улсын дата төвийн TIER III стандартыг хангаж ажилласан өндөр үзүүлэлттэй байв. Харилцагч, хэрэглэгчдийн сэтгэл ханамж өнгөрсөн оноос 10%-иар нэмэгдсэн байгаа нь дээрх ажлуудын үр дүнтэй салшгүй холбоотой юм.

Бид 2021 онд Дархан хотын нөөц дата төвөө ашиглалтанд оруулж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн цаашид эрүүл мэнд, боловсрол, санхүүгийн болон бусад бүхий л салбарт хувь хүн, ААНБ-ын үнэ цэн болсон датаны аюулгүй байдлыг хангах, найдвартай хамгаалах зарчимд тулгуурлан ISO:27001 мэдээллийн аюулгүй байдлын олон улсын сертификатын баталгуужуулалтыг хийлгэх зорилт тавин ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас түүхэндээ анх удаа мэдээллийн технологийн салбарыг эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэгээр зарласан нь бидэнд хийж бүтээх асар их боломж, итгэл найдвар өгсөн үйл явдал боллоо гэдгийг онцлон дурдмаар байна. Шавхагдашгүй оюунаар дэлхийтэй мөр зэрэгцэн алхах боломж бидэнд бий. Хүн төрөлхтний ирээдүй болсон мэдээллийн технологийн салбарт үнэлж баршгүй хувь нэмэр оруулан яваа эрхэм хөрөнгө оруулагч та бүгдийн ажил, амьдралд хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

2021 онд “Айтүүлс” ХК-ийн 10 жилийн ой тохиож буйтай холбогдуулан ирэх 10 жилийнхээ урт болон дунд хугацааны стратеги, төлөвлөгөөг боловсруулж, цаашид Монгол улсын төдийгүй дэлхийн 7 тэрбум хүн рүү чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхээр зорьж байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах /үйлчилгээ үзүүлэх/ замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллах

АЛСЫН ХАРАА

Дэлхийн жишиг дата төв болж, бүтээгдэхүүн үйлчилгээгээ дэлхийд экспортолно

ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛ

Компани төдийгүй эх орныхоо төлөө бие сэтгэл, мэдлэг чадвараа бүрэн дайчлан ажиллаж буй бизнесийн ёс зүйтэй баг хамт олон

Мэдээллийн технологийн үнэ цэнийг ойлгож үргэлж хамт байдаг хэрэглэгч, харилцагч, бизнесийн түншүүд
Дэлхийд чанараар өрсөлдөх бүтээгдэхүүн, үйлчилгээ
Харилцагчийн мэдээллийн аюулгүй байдал

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

Ёс суртахуунтай, ил тод, нээлттэй
Хууль, эрх зүйн хэм хэмжээг дээдэлнэ
Мэдээллийн аюулгүй байдлыг чандлан сахина

УРИА ҮГ

Зогсолтгүй хөгжиж, амжилтаараа ялгаръя



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

“Айтүүлс” ХК-ийн гол зорилго нь Монгол улсын эдийн засаг, мэдээллийн технологийн салбарт хувь нэмрээ оруулж, чанартай, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээр баялаг бүтээхийн зэрэгцээ, олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд компанийн зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигчдэд үнэ цэн хүртээх явдал билээ. Энэхүү гол зорилгынхоо хүрээнд бид 2020 оны үйл ажиллагаандаа дараах зорилго, зорилтуудыг тавин ажилласан. Үүнд

ICS бүтээгдэхүүнийг зах зээлд нутагшуулах, хөгжүүлэх

1

2019 онд “Фибо Клауд” ХХК-тай хамтран хөгжүүлж эхэлсэн үндэсний клауд үйлчилгээ болох ICS-ыг зах зээлд нэвтрүүлж, худалдан борлуулж эхэллээ. Тус бүтээгдэхүүн, үйлчилгээг таниулах, хэрэглэгчээ сургах, давуу талуудыг харуулж, мэдрүүлэх зорилгоор 6 сарын хугацаанд хэрэглэгчдэд үнэ төлбөргүй хэрэглүүлсэн нь тус бүтээгдэхүүнийг бодитоор турших, засаж сайжруулах зүйлсээ таньж мэдэх боломжийг олгосон явдал байлаа.

Шинээр хөгжүүлсэн бүтээгдэхүүнүүд

2

Цар тахал, хөл хорионы нөхцөл байдлаас шалтгаалан зөвхөн хостингийн үйлчилгээгээр зогсохгүй цахим хурлын платформ, сургалтын менежментийн систем зэргийг нэмж хөгжүүлсэн нь 2020 оны томоохон ажлуудын нэг байв. Эдгээр үйлчилгээний хүрээнд БШУЯ-тай хамтын ажиллагааг эхлүүлж арван хоёр дугаар сарын байдлаар улсын болон хувийн 30 орчим ЕБС-ийг сургалтын удирдлагын цогц системээр хангаад байна.

Санхүүгийн дата төвийг бүрэн ашиглалтанд оруулах

3

2019 оны ХЭЭХ-аас гарсан шийдвэрийн хүрээнд Улаанбаатар хотын дата төвийн 1-р давхарт “Санхүүгийн дата төв”-ийг төлөвлөгөөний дагуу бүрэн ашиглалтанд оруулж санхүүгийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг, банк санхүүгийн байгууллагуудад үйлчилгээ үзүүлэгч компаниудыг харилцагчаараа татаж чадлаа. Түүгээр ч зогсохгүй хөрөнгийн зах зээл, даатгал, ББСБайгууллагууд ч тус дата төвийн хэрэглэгч болж, хамтын ажиллагаагаа өргөжүүлсээр байна.

Тус дата төв нь 42 юнитийн нийт 8 ширхэг раг бүхий серверийн өрөө юм. 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 5 раг бүрэн дүүргэлттэй буюу 63 хувийн ашиглалттай байна.

Дэд бүтцийн өргөтгөл сайжруулалт хийх

4

Энэхүү зорилтын хүрээнд, хэрэглэгчдэд хүргэж буй бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах үүднээс УБ дахь дата төв болон санхүүгийн дата төвийн дэд бүтэц, тоног төхөөрөмжийг сайжруулан, өргөтгөл, шинэчлэлт хийх ажлуудыг үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Энэхүү дэд бүтцийн өргөтгөлийн үр дүнд “Айтүүлс” ХК-н дата төвүүдийн тасралтгүй найдвартай ажиллагааны үзүүлэлтүүд сайжирч 99.7 хувьд хүрлээ.

Харилцагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх

5

Жилээс жилд харилцагчийн тоо нэмэгдэж байгааг үүний дотор үнэнч, тогтвортой хэрэглэгч, үйлчлүүлэгчийн тоо өсч байгааг тоон үзүүлэлтээс харж болохоор байна. 2018 оны байдлаар нийт хэрэглэгчийн тоо 5290 байсан ба үүнээс 2279 буюу 43.1% харилцагч идэвхтэйгээр бүтээгдэхүүн, үйлчилгээ захиалан, ашиглаж байсан.

2019 оны байдлаарх нийт хэрэглэгчийн тоо 6957 болж өссөн бөгөөд үүнээс 2772 буюу 40% харилцагч идэвхтэйгээр бүтээгдэхүүн, үйлчилгээ захиалан, ашиглаж байсан бол тайлант оны байдлаар хэрэглэгчийн тоо 9140 хүрсэн үзүүлэлттэй байна. Үүнээс 3594 буюу 39.3% харилцагч идэвхтэйгээр бүтээгдэхүүн, үйлчилгээгээ захиалан, ашиглаж байна.

Технологи хөгжүүлэлтийн албанд тус онд нийт 12,449 удаагийн утасны дуудлага ирсэн ба энэ нь өдөрт дундчилбал 34-35 дуудлага юм. Мөн нийт 3181-н тусламжийн хүсэлт ирж, техникийн тусламжийн хүсэлтийг цаг тухай бүрт нь шийдвэрлэж 24/7 ажилласан байна.

Тусламжийн хүсэлт илгээж асуудлаа шийдвэрлүүлсэн харилцагчдын сэтгэл ханамжийн үзүүлэлт 2020 онд 10 онооноос 9.38 буюу 93.8% сэтгэл ханамжтай байна. Тусламжийн хүсэлтийг цаг алдалгүй, түргэн шуурхай үзүүлэх нь хэрэглэгч, харилцагчийн сэтгэл ханамжид шууд нөлөө үзүүлж байна. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг нийт идэвхтэй хэрэглэгчдийн 5 хувьд түүврийн аргаар хийсэн бөгөөд өмнөх онтой харьцуулбал сэтгэл ханамжийн хувь 18 орчим хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хувьцаа эзэмшигчид

6

Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн талаарх үнэн зөв мэдээллээр хувьцаа эзэмшигчдийг тогтмол хангаж байх нь оролцогч талуудаас хамаарч үүсэх эрсдэлийг бууруулах, итгэлцлийг бататгах, тэдний өмнө хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх гэх мэт ач холбогдолтой билээ. Бид гарсан өөрчлөлтийн дүн мэдээ, үйл ажиллагааны тайлан гэх мэт баримт бичгүүдийг цаг тухай бүрт нь холбогдох хороо, биржүүдэд хүргүүлэн ажилласан юм. Энэ хүрээнд 2020 оны ХЭЭХ-ыг цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулж, өөрсдийн хөгжүүлсэн санал хураах, санал тоолох програмыг амжилттай ашигласан.

Бидний хувьд компанийнхаа зах зээлийн үнэлгээг өсгөх, хувьцаа эзэмшигчдэдээ урт хугацааны тогтвортой өсөлт, өгөөжийг өгөхөөр зорин ажилладаг. Сүүлийн жилүүдэд компанийн борлуулалт, ашигт ажиллагаа тогтмол нэмэгдэж, санхүүгийн хувьд эрүүл, тогтвортой бүтэцтэй, ил тод, нээлттэй ажилласаар ирсэн. 2021 оны 5 сард ХЭ-ийнхээ өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу Дарханы дата төвийг бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байгаагаа дурдахад таатай байна.

Уг дата төвийг ашиглалтанд оруулснаар улсын хэмжээнд TIER III стандартыг хангасан дата төв нэгээр нэмэгдэх ба банк, санхүүгийн салбар, эрүүл мэнд, боловсрол зэрэг стратегийн чухал ач холбогдол бүхий салбаруудын мэдээллийг аюулгүй найдвартай хадгалах, компанийн үйл ажиллагаа өргөжиж, үнэлгээ нэмэгдэнэ. Цаашилбал дэлхий нийтээрээ цахим шилжилтэд хурдацтайгаар нэгдэж буй, мэдээллийн энэ эрин үед Монгол улсын мэдээллийн технологийн дэд бүтцийн хөгжилд бодит хувь нэмрийг оруулна гэдэгт бүрэн итгэлтэй байна. Уг дата төвийг бид TIER III стандартад тохирсон дизайн, шийдэл, техникийн үзүүлэлттэйгээр хийж байгаа бөгөөд цаашдаа уг стандартын баталгаажилтыг албан ёсоор авахаар ажиллах төлөвлөгөөтэй байна.

Хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөрүүд

7

2020 онд үндсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулбал 31 хувиар өссөн байна. Тайлант онд “Ард санхүүгийн нэгдэл” ХК, “Дата бэйнк” ХХК, “Инвескор ББСБ” ХК, “Эрдэнэс Таван Толгой” ХК зэрэг салбар салбарын тэргүүлэгч компаниудтай хамтын ажиллагааг эхлүүллээ.

Мөн төрийн болон хувийн өмчит ААН, байгууллагаас зарласан 40 орчим хамтын ажиллагаа, зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад оролцсоноос 20 хувьд нь амжилттай шалгарч, зөвлөх үйлчилгээ болон бүтээгдэхүүн үйлчилгээг нийлүүлэх төсөл хөтөлбөрүүд дээр хамтран, амжилттай ажиллалаа. Үүнээс дурдвал “Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг”, “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар”, “Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв” зэрэг байна.



ЗОРИЛГО

“Айтүүлс” ХК-ийн үйл ажиллагааны гол зорилго нь Монгол улсын эдийн засаг, мэдээллийн технологийн салбарт хувь нэмрээ оруулж, чанартай, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээр баялаг бүтээхийн зэрэгцээ, олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд компанийн зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигчдэд үнэ цэн хүртээх явдал юм. Энэхүү гол зорилгынхоо хүрээнд бид 2021 оны үйл ажиллагаандаа дараах зорилго, зорилтуудыг тавин ажиллаж байна. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх
2. Борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх
3. Харилцагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх

ЗОРИЛТУУД

Дээр дурдсан гурван зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн, эдгээр зорилтуудын дагуу авах арга хэмжээний богино хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулж ТУЗ-ийн тогтоолоор батлууллаа. Үүнд:


1. ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ, НЭВТРҮҮЛЭЛТ

2021 онд “Айтүүлс” ХК-с шинээр хэд хэдэн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, өргөтгөх зорилт тавьсан ба үүнд, веб сайт хялбар угсралтын үйлчилгээ, вордпресс (wordpress) хостинг үйлчилгээ, масс и-мэйлийн үйлчилгээг хөгжүүлэн, хэрэглэгчдэд хүргэхээр төлөвлөв. Мөн “Фибо Клауд” ХХК-тай хамтран “Үүлэнхүү” үндэсний үүлэн технологийн платформын хүчин чадлыг өргөтгөх, “LMS” сургалтын удирдлагын цогц системийн сайжруулалт, хөгжүүлэлтийн ажлыг хийхээр төлөвлөв.



2. ДАРХАН ХОТ ДАХЬ ДАТА ТӨВИЙГ АШИГЛАЛТАНД ОРУУЛАХ

Дархан хот дахь дата төвийг ашиглалтанд оруулах нь “Айтүүлс” ХК-ийн хувьд хувьцаа эзэмшигчдийн итгэл үнэмшлийг бататгах, цаашдын үйл ажиллагааг өргөжүүлэн, илүү найдвартай, аюулгүй болгох, олон улсын дата төвийн чанар стандартад нийцсэн үйлчилгээг харилцагчиддаа үзүүлэх талаас ач холбогдлын зэрэг өндөртэй зорилт юм. Тиймээс энэхүү ажлыг төлөвлөх, гүйцэтгэх тал дээр онцгой анхаарч ажиллах бөгөөд компанийн зүгээс шаардагдах хөрөнгө оруулалтыг цаг алдалгүй хийж, товлосон хугацаанд гүйцэтгэж, ашиглалтанд оруулах төлөвлөгөөтэй байна. Энэхүү төслийн хөрөнгө оруулалтыг компанийн өөрийн хөрөнгөөр болон зээлийн эх үүсвэрээр шийдэхээр төлөвлөсөн.



3. ДЭД БҮТЭЦ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШИНЭЧЛЭЛТ ХИЙХ

Энэхүү зорилтын хүрээнд, хэрэглэгчдэд хүргэж буй бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах үүднээс УБ дахь дата төв болон санхүүгийн дата төвийн дэд бүтэц, тоног төхөөрөмжийг сайжруулан, өргөтгөл, шинэчлэлт хийх ажлуудыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөв.



4. ХАРИЛЦАГЧ, ХЭРЭГЛЭГЧДИЙГ СУРГАХ, ХАЛАМЖЛАХ

Харилцагчдын дийлэнх гомдол санал нь зарим бүтээгдэхүүн үйлчилгээ бүрэн автоматжуулагдаагүйтэй холбоотой байна. Иймд бүх бүтээгдэхүүн үйлчилгээг автоматжуулах ажлууд хийхээр төлөвлөж байна. Мөн потенциал үйлчлүүлэгч бүрийг хэрэглэгч болгох, түүнчлэн хэрэглэгчийн асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгааг үнэлэх, дүгнэх, гомдол саналын мөн чанар, шалтгааныг тодорхойлох үүднээс CRM системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.


Клауд үйлчилгээ нь Монголын зах зээлд шинээр нэвтэрч буй үйлчилгээ тул хэрэглэгчдийг сургах зайлшгүй шаардлага үүсч байна. Цаашид тус үйлчилгээний хэрэглэгчдийг үе шаттайгаар сургах, мэдлэгийг тэлэх зорилгыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгав.



5. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ

Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн талаарх үнэн зөв мэдээллээр хувьцаа эзэмшигчдийг тогтмол хангаж байх нь оролцогч талуудаас хамаарч үүсэх эрсдэлийг бууруулах, итгэлцлийг бататгах, тэдний өмнө хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх гэх мэт ач холбогдолтой тул 2021 оноос улирлын тайлангуудыг боловсруулахын зэрэгцээ эдгээр тайлангуудад шинжилгээ хийж хувьцаа эзэмшигчдэд хүргэх төлөвлөгөөтэй байна. Энэ нь компанийн санхүүгийн үзүүлэлтүүдийг тогтмол хугацаанд хянаж байх, харьцуулалт хийж зүй тогтлыг олж тогтоох, шаардлага хангахгүй үзүүлэлтийг эрт илрүүлэх, үүний дагуу шаардлагатай арга хэмжээг хэлэлцэх, цаашид компанийн санхүү, олон улсын НБББББ-ын стандарт, сахилга батыг дээшлүүлэхэд чухал нөлөөтэй гэж үзэж байна.





САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ





“АЙТҮҮЛС” ХК-ний
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;
Цахим ирүүдэл: altantsetseg@sdaudit.mn

2021.03.18 № СТА/21-18
төвийн _____ -ны № _____ -т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “Айтүүлс” ХК-ний 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол ондөртэй нягтлан бодох бүртгэлийн чухал бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бид “Айтүүлс” ХК-ний 2020 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүхний л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (иашид “СТОУС” гэх)-ын дагуу үзэн зөв, шударгаар нэгэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (иашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг Харууцлага гэсэн хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (иашид “НБЭЗОУСЭ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг харууцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их нөлөөтэй асуудал байна. Бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд харууцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээлэлээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан ордоггүй. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажуулалтын дүгнэлт

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)
“АЙГҮҮҮЛС” ХК-ний Хувьцаа Эзэмшигчдэд (үргэлжлэл)

гаргахгүй. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг уншиж, уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ.

Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах бөтөй. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах зүйл байхгүй болно.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлэлээс ангид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм.

Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг.

Бид мөн дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага (үргэлжлэл)

- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бүр тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилттай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог.

Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг гаргах өдөр хүргэлх олж авсан аудитын баримт нотолгоонд суурилна. Компанийн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг бид бүхэлд нь үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай зөвхөн аудитын ажлын хамрах хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудын талаар харилцсан.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94-р зүйлд заасны дагуу Компанийн Хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2021 оны сарын



ДАЛТАНЦЭЦЭГ
Захирал, МНБ

2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЛАНС. /МЯНГАН ТӨГРӨГӨӨР/



ҮЗҮҮЛЭЛТ	2018	2019	2020
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	28,764	74,549	174,871
Дансны авлага	181,147	1,182,859	656,548
Татвар, НДШ-ийн авлага		-	
Бусад авлага	321,189		1,531
Бусад санхүүгийн хөрөнгө		-	-
Бараа материал	90,356	106,532	95,317
Урьдчилж төлсөн зардал тооцоо	520,510	244,705	146
Бусад эргэлтийн хөрөнгө		-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,141,965	1,632,047	928,413
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	2,256,421	1,471,807	1,465,431
Биет бус хөрөнгө	132,250	124,289	91,760
Биологийн хөрөнгө	-	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	70,446	70,446	70,446
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-	-
Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	1,008,172	1,008,172
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,459,117	2,674,715	2,635,810
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,601,082	4,306,761	3,564,223
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	60,176	710,574	41,335
Цалингийн өглөг	3,919	243	551
Татварын өр	120,315	95,313	59,989
НДШ-ийн өглөг	3,165	-	-
Богино хугацаат зээл	-	-	-
Хүүний өглөг	-	-	-
Ногдол ашгийн өглөг	-	-	-
Урьдчилж орсон орлого	245,745	301,050	-
Нөөц / өр төлбөр /	-	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	173,169	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр	-	-	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	606,489	1,107,179	101,875
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	-	-	-
Нөөц / өр төлбөр/	-	-	-
Хойшлогдсон татварын өр	1,042	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,042	-	-
Өр төлбөрийн нийт дүн	607,531	1,107,179	101,875
Эздийн өмч			
Төрийн өмч	-	-	-
Хувийн өмч	905,758	1,481,441	1,481,441
Хувьцаат өр төлбөр	1,338,798	-	-
Халаасны хувьцаа	-	-	-
Нэмж төлөгдсөн капитал	-	763,115	763,115
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	460,722	460,722	460,722
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-	-
Хуримтлагдсан ашиг	288,274	494,304	757,070
Эздийн өмчийн дүн	2,993,551	3,199,582	3,462,348
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	3,601,082	4,306,761	3,564,223

2018, 2019, 2020 ОНУУДЫН ЖИЛИЙН ЭЦСИЙН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН /МЯНГАН ТӨГРӨГӨӨР/

Үзүүлэлт	2018	2019	2020
Борлуулалтын орлого (цэвэр)	1,512,816	3,086,785	3,234,369
Борлуулалтын өртөг	597,986	2,385,417	2,282,147
	914,830	701,367	952,222
Түрээсийн орлого	10,909	19,320	19,545
Хүүгийн орлого	429	1,048	630
Ногдол ашгийн орлого	-	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-	-
Бусад орлого	162	34,740	5,321
Борлуулалт, маркетингийн зардал	-	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	742,680	508,026	648,967
Санхүүгийн зардал	-	-	-
Бусад зардал	7,732	18,154	31,198
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	5,945	2,556	2,176
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	9,331	(1,911)	(4,302)
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-	-
Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	-	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	191,195	230,940	295,429
Орлогын татварын зардал	19,893	24,909	32,663
Татварын дараах ашиг (алдагдал)	171,302	206,031	262,766
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	171,302	206,031	262,766
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
Бусад олз (гарз)	-	-	-
Орлогын нийт дүн	171,302	206,031	262,766
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	4.97	5.98	7.63

2018, 2019, 2020 ОНУУДЫН ЖИЛИЙН ЭЦСИЙН МӨНГӨН УРСГАЛЫН ТАЙЛАН. /МЯНГАН ТӨГРӨГӨӨР/

ҮЗҮҮЛЭЛТ	2018	2019	2020
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	1,372,858	3,033,215	2,905,335
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	1,364,966	2,654,913	2,895,476
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-	-
Буцаан авсан албан татвар	-	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-	-
Бусад мөнгөн орлого	7,892	378,302	9,859
Мөнгөн зарлагын дүн (-)	1,423,609	2,789,167	2,729,022
Ажиллагсадад төлсөн	207,140	281,288	269,446
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	55,637	82,553	34,302
Бараа материал худалдан авахад төлсөн	467,505	1,486,394	2,091,929
Ашиглалтын зардалд төлсөн	108,880	172,974	2,849
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,000	4,284	-
Хүүний төлбөрт төлсөн	-	-	-
Татварын байгууллагад төлсөн	47,794	324,657	152,838
Даатгалын төлбөрт төлсөн	-	-	450
Бусад мөнгөн зарлага	533,653	437,018	177,207
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(50,751)	244,048	176,314
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	27,872	158,114	1,149,089
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	140	-	-
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	-	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	-	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	-	-	-
Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	27,303	157,445	1,148,459
Хүлээн авсан хүүний орлого	429	669	630
Хүлээн авсан ногдол ашиг	-	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	434,236	457,741	1,199,506
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	338,822	310,932	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-	-
Бусад олгосон зээл болон урьдчилгаа	95,414	146,809	1,199,506
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(406,364)	(299,627)	(50,417)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	124,022	364,295	116,876
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	124,022	364,295	114,365
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-	-
Төрөл бүрийн хандив	-	-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	-	2,511
Мөнгөн зарлагын дүн (-)	56,098	266,372	142,450
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	56,098	266,372	142,265
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-	-
Хувьцаа буцаан худалдаж төлсөн	-	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-	-	185
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	67,924	97,923	(25,574)
Валютын ханшийн зөрүү	5,945	3,441	1,149,089
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(383,245)	45,785	100,322
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	412,009	28,764	74,549
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,764	74,549	174,871

2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН. /МЯНГАН ТӨГРӨГӨӨР/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,481,441.36	0.	763,114.86	763,114.86	0.	0.	494,304.24	3,199,582.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
Залруулсан үлдэгдэл	1,481,441.36	0.	763,114.86	763,114.86	0.	0.	494,304.24	
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.	0.	0.	0.	0.	0.	262,765.95	262,765.95
Бусад дэлгэрэнгүй орлого	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
Өмчид гарсан өөрчлөлт	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
Зарласан ногдол ашиг	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,141,965	0.	763,114.86	763,114.86	0.	0.	757,070.19	3,462,348.06

Баланс

2020 оны эцсийн байдлаар компанийн нийт хөрөнгө 3,56 тэрбум төгрөг, 2019 онд 4,3 тэрбум харин 2018 онд 3,6 тэрбум төгрөг байжээ.

2018 онд үндсэн хөрөнгөөр бүртгэсэн байсан дуусаагүй барилгын дүнг үндсэн хөрөнгөөс хасаж бусад эргэлтийн бус хөрөнгөөр залруулан бүртгэсэн явдал нь үндсэн хөрөнгийн хэмжээ буурсны шалтгаан болсон байна. 2020 оны хувьд дансны авлага 2 дахин буурсан, урьдчилж төлсөн зардал буурсан ба бусад хөрөнгийн хувьд харьцангуй тогтвортой байсан.

Нийт хөрөнгөд эзлэх эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн харьцаа харьцангуй тогтвортой буюу эргэлтийн хөрөнгө нь 2018 онд 32%, 2019 онд 38%, 2020 онд 26%-ийн эзэлж байна. 2020 оны эргэлтийн хөрөнгийн бууралт нь дээр дурдсанчлан дансны авлагын бууралтаас үүдэлтэй юм. Компанийн хөрөнгийн бүтцийг харахад үйл ажиллагаагаа ихэвчлэн эздийн өмчөөр санхүүжүүлж ирсэн бөгөөд 2020 онд ялангуяа нийт үйл ажиллагааны 97%-г эздийн өмчөөр, 3%-г өр төлбөрөөр санхүүжүүлж байна. Энэ нь үйл ажиллагаандаа маш бага санхүүгийн хөшүүрэг ашиглаж байгааг илэрхийлэх ба ингэснээр эрсдэлийг бууруулж буй ач холбогдолтой ч хөрөнгийн өгөөжийг бууруулах хандлагатай гэж тооцдог.


Иймээс компанийн хувьд хамгийн оновчтой хөрөнгийн бүтцийг олж тогтоон зарим үйл ажиллагааг өрийн капиталаар санхүүжүүлэх, капиталын бүтцэд эзэлж буй санхүүгийн хөшүүргийг оптимал төвшинд хүртэл нэмэгдүүлэх нь компанийн үнэ цэнийг өсгөхөд эергээр нөлөөлөх боломжтой гэж үзэж байна. Үйл ажиллагааг өрийн капиталаар санхүүжүүлэхдээ компанийн урт болоод богино хугацааны өр төлбөр төлөх чадвар, эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалт хийх төслийн өгөөж, эрсдэл гэх мэт бүх хүчин зүйлсийг тооцож, хамгийн үр ашигтайгаар зарцуулахад цаашид анхаарал хандуулж ажиллана.

Өр төлбөр ба эздийн өмчийн хувьд өр төлбөр нь 2020 онд зөвхөн богино хугацаат өглөгүүдээс бүтэж байсан ба урт хугацаат өр төлбөр байхгүй байна. 2020 онд дансны өглөг эрс буурсан байгаа нь богино хугацаат өр төлбөрийн дүнг багасгасан байна. 2020 онд компанийн хувьд богино болон урт хугацааны өрийн дарамтгүйгээр ажиллалаа.


Дараах диаграммуудаас компанийн үйл ажиллагааг санхүүжүүлж буй бүрэлдэхүүн хэсгүүдийн хувь хэмжээ хэрхэн өөрчлөгдсөнийг мөн нийт хөрөнгийн бүтэц болоод өр төлбөр эздийн өмчийн хэмжээ болон бүтэц 2018-2020 онуудад хэрхэн өөрчлөгдсөнийг харж болно.

Компанийн хөрөнгийн бүтэц буюу нийт хөрөнгийн хэдэн хувийг эздийн өмч, өр төлбөрөөр санхүүжүүлж ирснийг 3 жилээр харьцуулсан харьцуулалт

Компанийн хөрөнгийн бүтэц




Нийтийн хөрөнгийн бүтэц



- Эргэлтийн бус хөрөнгө
- Бараа материал ба бусад эргэлтийн хөрөнгө
- Дансны ба бусад авлага
- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Өр төлбөр ба эздийн өмч




- Хуримтлагдсан ашиг
- Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл
- Нэмж төлөгдсөн капитал
- Хувьцаат өр төлбөр
- Хувийн өмч
- Урт хугацаат өр төлбөр
- Богино хугацаат өр төлбөр
- Өр төлбөр ба эздийн өмч

Нийт хөрөнгө ба өр төлбөр, эздийн өмчийн бүтцийг 3 жилээр харьцуулан харууллаа.

Орлогын тайлан


2020 оны хувьд борлуулалтын орлого өмнөх оныхоос 5% өссөн, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 4% буурсан үзүүлэлттэй байна. 2020 онд Дархан хот дахь крипто фармын үйл ажиллагааг өртөг өссөн шалтгаанаар зогсоосон ч бусад бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтын орлогыг нэмэгдүүлснээр 2020 оны төлөвлөгөөнөөс борлуулалтыг давуулан биелүүлсэн байна. 2020 онд ББӨ буурсны нэг шалтгаан нь өндөр өртөг бүхий крипто фармыг хаасан явдал байна.

Борлуулалтын орлогод хамгийн өндөр хувь эзэлж буй үйл ажиллагаа нь нэгд, тендерийн борлуулалт (50%), VPS үйлчилгээ (10%), МН домэйн үйлчилгээ (9.6%) байна. Бүтээгдэхүүн тус бүрээр авч үзвэл, крипто фарм, co-location, багтаамж нэмэх үйлчилгээний борлуулалтын орлого буурсан, бусад бүтээгдэхүүн үйлчилгээний орлого бүгд өсөлттэй гарсан байна



Борлуулалтын орлого, ББӨ, цэвэр ашгийн сүүлийн 3 жилийн харьцуулалт


2019 ба 2020 онуудад борлуулалтын орлогын эх үүсвэрийн өөрчлөлтийг доорх графикаар харуулж байна. Тендерийн орлого өмнөх оныхоос 25% өсөлттэй, бүтээгдэхүүн үйлчилгээний орлого 63% өсөлттэй, харин Дарханы крипто фармын үйл ажиллагаанаас олдог орлого 100% буурч, 0 болсон үзүүлэлттэй байлаа. Хэдийгээр 2020 онд Дарханы крипто фармын үйл ажиллагааг бүрэн зогсоосон ч энэ борлуулалтыг бусад бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтыг нэмэгдүүлэх замаар нөхөж амжилттай ажиллалаа.



Цэвэр ашгийн маржин

Цэвэр ашгийн маржин нь 2019 онд 7% байсан бол 2020 онд 8% болж өссөн байна. 2018 онтой харьцуулахад ашгийн маржин буурч байгаа нь компанийн ББӨ, үйл ажиллагааны зардал зэрэг нь нэмэгдсэн ч, бараа үйлчилгээний үнэ харьцангуй тогтвортой байгаагаас шалтгаалсан гэж үзэж байна.

	2018	2019	2020
Цэвэр ашиг	171,302	206,031	262,766
Борлуулалтын орлого	1,512,816	3,086,785	3,234,369
Цэвэр ашгийн маржин	11%	7%	8%




Нийт хөрөнгийн болон эздийн өмчийн өгөөж

Хүснэгтээс харахад Нийт хөрөнгийн өгөөж болон Эздийн өмчийн өгөөж нь 2018 оноос хойш байнгын өсөлттэй байна. Энэ нь дээр дурдсанчлан компанийн хөрөнгийн эх үүсвэрийн бүтээмж өсч байгааг үзүүлж байна.

	2018	2019	2020
Цэвэр ашиг	171,302	206,031	262,766
Нийт хөрөнгө (дундаж)	3,379,164	3,953,922	3,935,492
ROA	5.1%	5.2%	6.7%

	2018	2019	2020
Цэвэр ашиг	171,302	206,031	262,766
Нийт эздийн өмч (дундаж)	2,907,900	3,096,567	3,330,965
ROE	5.9%	6.7%	7.9%



Нэгж хувьцаанд ногдох ашиг, /алдагдал/ P/E харьцаа болон дансны үнэ

Нэгж хувьцаанд ногдох ашиг/алдагдал/ болон P/E харьцаа нь потенциал хөрөнгө оруулагчдын хувьд тухайн компанийн үнэ цэнийг тодорхойлоход маш чухал харьцаа бөгөөд бусад хувьцаануудтай харьцуулалт хийн, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад ач холбогдолтой байдаг. Зөвхөн компанийн үзүүлэлтээс гадна хувьцааны үнийг голлон авч үзсэнээрээ хөрөнгө оруулагчдын хүлээлтийг (өсөх магадлалтай эсэх), мөн тухайн хувьцаа хэт үнэлэгдсэн байгаа эсэхийг мөн илэрхийлж байдаг. Дараах хүснэгтүүдээс нэгж хувьцаанд ногдох ашиг ба 2019, 2020 онуудын P/E харьцааг харна уу.

	2018	2019	2020
Цэвэр ашиг	171,302	206,031	262,766
Хувьцааны тоо	34,452	34,452	34,452
EPS	4.97	5.98	7.63


	2019	2020
EPS	5.98	7.63
Хаалтын ханш (12 сарын 31-ээр)	72.36	82.83
P/E харьцаа	12.1	10.86

	2018	2019	2020
Нийт хөрөнгө	3,601,082	4,306,671	3,564,223
Өр төлбөр	607,531	1,107,179	101,875
Дансны үнэ	86.9	92.9	100.5


Снэт ХХК

Айтүүлс ХК-ийн ХЭХ-ын 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 19/02 дугаартай тогтоолоор 100 хувь охин компани болсон.

БОРЛУУЛАЛТ 14%




ЦЭВЭР АШИГ 13.8 сая



АШГИЙН МАРЖИН 11%




ЗАРДАЛ+ ӨРТӨГ -30%



ЦЭВЭР АШГИЙН МАРЖИН 10%



ОРЛОГЫН ТӨРӨЛ



- Интернетийн үйлчилгээ
- Шилэн кабель кор түрээсийн үйлчилгээ



Бид санхүүгийн тайлант жилийн хугацаанд борлуулалтын орлогыг 5 хувиар нэмэгдүүлж, нийт ашгийг 28 хувиар өсгөж ажилласан нь төлөвлөсөн төлөвлөгөөндөө хүрч ажилласныг илтгэж байна. Цаг үеийн нөхцөл байдал, ЗГ-ын гэнэтийн шийдвэрүүдээс шалтгаалж олон эрсдэл, саад бэрхшээл цаг тутамд тулгарч байсан ч аливаа асуудлыг боломж болгох, шийдвэр гаргалтыг оновчтой байлгаж чадсанаар дараах үзүүлэлт, дүгнэлтүүд гарч байна. Үйл ажиллагааны бүтээмж, эх үүсвэрийн үр ашигт байдал, богино хугацаат болон урт хугацаат өр төлбөрийн чадвар зэргийг хэмжих харьцаа, эдгээрийн үр дүнгээс дурдвал:

БҮТЭЭМЖ

2018-2020 онуудын хооронд авлага өглөгийн эргэц буурснаас бусдаар эргэцийн харьцаанууд сайжирсан үзүүлэлттэй, эх үүсвэрүүдийг илүү хурдан буюу бүтээмжтэй эргэлдүүлж иржээ. Анхаарал хандуулах шаардлагатай зүйл нь авлагын эргэцийг нэмэгдүүлж, авлага цуглуулах хугацааг багасгах шаардлагатай байна гэсэн дүгнэлтэд хүрлээ. Авлагын чанарыг тодорхойлж, өглөг авлагын эргэцийг аль болох ойролцоо байлгах нь богино хугацааны хөрвөх чадварыг сайжруулна.

АШИГТ АЖИЛЛАГАА

Ашгийн маржинууд (нийт ашиг/gross profit/ болон цэвэр ашиг) 2018 онтой харьцуулахад 2019 онд унасан, 2020 онд 2019 онтой харьцуулахад эргээд өссөн үзүүлэлттэй байв. 2019 оны унасан шалтгаан нь өртөг өссөнтэй холбоотой гэж үзсэн бөгөөд өнгөрсөн жилтэй харьцуулахад борлуулалтын орлого 28%-р өссөн ч өртөг 4%-р буурсан. Энэ нь Дархан хотын Крипто фармын үйл ажиллагаатай шууд хамааралтай юм. Нийт хөрөнгө болон эздийн өмчийн өгөөж 3 жилийн турш байнга өссөн байна. ДюПон анализаар эздийн өмчийн өгөөжийн ард буй хүчин зүйлсийг задалсан. Нийт хөрөнгийн өгөөж, эргэц сайжирсан нь эздийн өмч өсөх гол шалтгаан болсон байна. 2020 онд 2019 онтой харьцуулахад санхүүгийн хөшүүрэг буурсан ч, хүүний дарамтгүй ажилласан байна. Нэгж хувьцаанд ногдох ашгийн үзүүлэлт мөн өнгөрсөн 3 жилд байнга өссөн байна.


УРТ ХУГАЦААТ ТӨЛБӨРИЙН ЧАДВАР

Компани сүүлийн 3 жилд урт хугацаат зээл, өр төлбөргүйгээр үйл ажиллагааг явуулсан тул урт хугацаат төлбөрийн чадварын эрсдэлгүй ажилласан байна. Үйл ажиллагаагаа ихэвчлэн эздийн өмч, богино хугацаат өр төлбөрөөр санхүүжүүлж ирсэн. Сүүлийн 3 жилийн санхүүгийн хөшүүргийг үзэхэд 2019 онд өс ч, 2020 онд буурсан үзүүлэлттэй байна. 2020 оны балансын эцсийн үлдэгдлийг харахад 3% өр төлбөр, 97% эздийн өмч байна. Өөрөөр хэлбэл 2020 онд үйл ажиллагаагаа эздийн өмчөөр санхүүжүүлсэн байна. Тиймээс үйл ажиллагаандаа санхүүгийн хөшүүрэг тодорхой хэмжээнд ашиглах орон зай байгаа гэж үзэж байгаа бөгөөд оптимал хэмжээг тодорхойлж, үр бүтээмжтэйгээр ашиглах нь ашигт ажиллагаанд эерэгээр нөлөөлөх юм.

ХӨРВӨХ ЧАДВАР


Хөрвөх чадварыг аль ч харьцаагаар хэмжсэн өнгөрсөн 3 жилийн хувьд байнгын өсөлттэй байсан буюу богино өр төлбөр барагдуулах чадвар маш сайн гэж дүгнэж байна. Энэ нь өр төлбөрийн хэмжээ өмнөх жилүүдтэй харьцуулахад 2020 онд ихээр багассантай холбоотой. Хөрвөх чадварыг илүү сайжруулах үүднээс дансны авлага болон өглөгийн эргэцийг хооронд нь ойролцоо байлгах, авлагыг чанаржуулж, авлага барагдуулах хугацааг багасгах нь зүйтэй учраас цаашид тогтмол анхаарч ажиллана.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 5-р сарын 15-ны өдрийн А 88 тоот тушаалаар “Айтүүлс” ХК-ийн нэг бүр нь 43 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, нийт 34,452,124 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэснийг Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 9-р сарын 27-ний өдрийн хурлаар хэлэлцэж, 173 тоот тогтоолоор нийт гаргасан хувьцааны 13,387,980 ширхгийг тус бүр 100 төгрөгийн үнээр нийтэд санал болгон худалдахыг зөвшөөрснөөр Айтүүлс ХК олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон.



2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн дүрмийг шинэчлэн баталсан. Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц нь 2020 оны байдлаар дараах байдалтай байна.

2019 оны эцсийн ханшийг 2020 оны эцсийн ханштай харьцуулахад 14%-ийн өсөлттэй гарсан бөгөөд 2020 онд өсөлтийн трендтэй байсан ба үүнийг 2021 онд хадгалж ажиллахыг зорино.





Г.Хатанболд

ТУЗ-ийн дарга

- Санхүүгийн удирдлагын магистр
- Ай Си Ти Групп ХК-ийн Гүйцэтгэх захирал



З.Мягмарсүрэн

ТУЗ-ийн хараат бус гишүүн

- Зах зээл судлаач, эдийн засагч
- Бодь тусгал Аудит ХХК-ийн захирал
- Аудитын хорооны дарга, нэр дэвшүүлэх хорооны гишүүн



Л.Тэмүүлэл

ТУЗ-ийн хараат бус гишүүн

- Эрх зүйн ухааны магистр
- Тэлмэн хас ББСБ-ийн Гүйцэтгэх захирал
- Нэр дэвшүүлэх хорооны дарга, цалин урамшууллын хорооны гишүүн



Г.Гантуяа

ТУЗ-ийн хараат бус гишүүн

- Бизнесийн удирдлагын докторант
- Бизнесийн удирдлагын магистр
- Номадик контент ХХК-ийн үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал
- Аудитын хороо, цалин урамшууллын хороо, мэдээллийн аюулгүй байдлын хорооны гишүүн



А.Баттамир

ТУЗ-ийн ердийн гишүүн

- Техникийн ухааны магистр
- Мэдээллийн аюулгүй байдлын хорооны дарга
- Ай Си Ти групп ХК-ийн үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн гишүүн



Н.Улаанхүү

ТУЗ-ийн ердийн гишүүн

- Эдийн засгийн онолч, эдийн засагч
- Цалин урамшууллын хорооны гишүүн
- Ай Си Ти групп ХК-ийн Төсөл хөтөлбөр, дотоод аудит хариуцсан захирал



Б.Эрдэнэжаргал

ТУЗ-ийн ердийн гишүүн

- Бизнесийн удирдлага
- Стандарт инвестмент ҮЦК ХХК-ийн диллер



Б.Тамир

ТУЗ-ийн ердийн гишүүн

- Улс төрийн удирдлагын магистр
- Айтүүлс ХК-ийн Гүйцэтгэх захирал



Д.Батцэцэг

ТУЗ-ийн ердийн гишүүн

- Нягтлан бодогч
- Аудитын хорооны гишүүн



Г.Янжинлхам

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

- Нийтийн удирдлага магистр, эрх зүйч

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Айтүүлс компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) 9 гишүүнээс бүрдсэн бөгөөд Компанийн тухай хуульд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Чиг үүргийг гүйцэтгэхдээ ТУЗ нь компани, түүнтэй харилцан хамааралтай этгээд болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг удирдамжаа болгодог. Мөн ТУЗ нь Айтүүлс компанийн бизнесийн стратегийг тодорхойлох, хэрэгжилтийг нь хангуулах, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо үр дүнтэй ажиллах, санхүүгийн бүртгэл, тайлагналын тогтолцоо хуульд нийцсэн байх, компанийн үйл ажиллагаа нь нийгмийн хариуцлагын зарчмыг даган мөрдөх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хамгаалагдсан байх зэрэг чиг үүргийг гүйцэтгэнэ.

ТУЗ нь Айтүүлс компанийн бизнесийн стратеги болон тулгарч буй эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, санхүүгийн бүртгэл, тайлагналын тогтолцооны үйл ажиллагааг жилд хамгийн цөөндөө нэг удаа хянан хэлэлцэж, шаардлагатай шийдвэрүүдийг гарган ажилладаг. ТУЗ-өөс жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг хянан, холбогдох үүрэг, чиглэлүүдийг өгч ажиллаж байна. Мөн ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулан компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Аудитын хороо
- Нэр дэвшүүлэх хороо
- Цалин урамшууллын хороо
- Мэдээллийн аюулгүй байдлын хороо

ТУЗ доторх чиг үүргийн хуваарилалтыг ТУЗ-ийн үйл ажиллагааны холбогдох дүрэм журмаар тодорхойлсон.

ТУЗ-ийн гишүүдийг сонгох, улираан томилох, хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгох зэрэг шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргана. ТУЗ-ийг 1 жилээр томилох бөгөөд улиран томилох боломжтой.

ТУЗ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга хариуцдаг бөгөөд ТУЗ-ийн ажлын албан үйл ажиллагааг удирдан ажиллана. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь компанийн засаглалтай холбоотой асуудлыг шууд хариуцах эрх бүхий албан тушаалтан болно.

Айтүүлс ХК нь мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч компани учир өөрийн компанийн онцлогт нийцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх "Мэдээллийн аюулгүй байдлын хороо"-г байгуулсан. 2020 онд Ковид-19 цар тахлын улмаас улсын хэмжээнд тогтоосон олон удаагийн хөл хорионы дэглэмтэй холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөл нь хурал уулзалтаа цахим хэлбэрээр төлөвлөсөн хугацаандаа зохион байгуулж, компанийн үйл ажиллагаанд шаардлагатай 9 тогтоол гаргаж компанийн стратегийг тодорхойлж үйл ажиллагааг чиглүүлэн, хяналт тавьж ажиллалаа.



